Эдийн засгийн хувьсагч үзүүлэлтүүд	- Нэг хүнд ногдох төсвийн зардал - Чанаргүй зээлийн хувь - Ажилгүйдлийн түвшин - Алслагдсан байдал
Нийгмийн хувьсагч үзүүлэлтүүд	- Мэргэжилгүй ажилгүй иргэд - Гэр бүл салалтын түвшин - Гэмт хэргийн түвшин - Нэг их эмчид ногдох хүний тоо
Байгаль орчны хувьсагч үзүүлэлтүүд	- Ой модыг огтолсон газар - Ойн түймэр - Ширгэсэн гол горхи - Мал сүргийн нягтрал (1 км²-д ногдох малын тоо) - Агаарын бохирдол NO₂ түвшин - Агаарын бохирдол SO₂ түвшин

Индекс тооцсон аргачлал

Индексийг нормчлох арга ашиглан тооцож гаргасан.

$$P_{ij} = \frac{P_{ij} - P_{i \min}}{P_{i \max} - P_{i \min}}$$

Энд: P_{ij} - j - р аймгийн i - р хувьсагчийн утга

$\max$ - 21 аймгийн хамгийн их утга

$\min$ - 21 аймгийн хамгийн бага утга

Индексийн утга 0-1-ийн хооронд хэлбэлзэнэ. Хувьсагч бүрийг эмзэг байдлыг илэрхийлэх үзүүлэлт гэж тодорхойлох бөгөөд хамгийн их утга нь эмзэг байдлын дээгүүр түвшинг илтгэнэ. Өөрөөр хэлбэл эмзэг байдалд хамгийн их нэрвэгдсэн аймаг хамгийн их утга (1) авч, сөрөг нөлөө хамгийн бага байсан аймаг хамгийн бага утга (0) авна.


Нөгөө талаар эмзэг байдлыг илэрхийлж болох хувьсагчдын оноогоор тухайн аймгийн эмзэг байдалд хамгийн ихээр нөлөөлж байгаа хувьсагч нь хамгийн өндөр буюу нэг гэсэн оноо эмзэг байдалд хамгийн бага нөлөөлж байгаа нь хамгийн бага буюу тэг оноо авна гэж ойлгож болно.

Байгаль орчны эмзэг байдлын олон хувьсагчтай хэмжүүрийн үр дүн /2022 оны статистик мэдээлэлд үндэслэв/


Архангай



Баян-Өлгий




Баянхонгор



Булган



Говь-Алтай




Говьсүмбэр




Дархан-Уул



Дорноговь




Дорнод



Дундговь



Завхан



Орхон



Өвөрхангай



Өмнөговь



Сүхбаатар



Сэлэнгэ



Төв



Увс



Ховд



Хөвсгөл




Хэнтий



Нэгдсэн үзүүлэлт

Байгаль орчны эмзэг байдлын олон хувьсагчтай хэмжүүрийн нэгдсэн үзүүлэлт нь арифметикийн нийлбэрийн аргаар тооцсноор 0-14-ын хооронд утга авах ба 0 гэсэн оноо нь тухайн аймаг 14 хувьсагчийн алиных нь ч хувьд эмзэг бус болохыг илэрхийлж, хамгийн дээд оноо болох 14 нь тухайн аймаг бүх 14 хувьсагчийн хувьд эмзэг байдлын хамгийн дээд түвшинд байгаа болохыг илтгэнэ.

Нэгдсэн үзүүлэлт



Ашигласан үзүүлэлтүүд

		Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Эх үүсвэр	Он
Эдийн засгийн Хувьсагч үзүүлэлтүүд	1	Нэг хүнд ногдох төсвийн зардал	Төгрөг	ҮСХ	2022
	2	Чанаргүй зээлийн хувь	Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	ҮСХ	2022
	3	Ажилгүйдлийн түвшин	Хувь	ҮСХ	2022
	4	Алслагдсан байдал	Аймгийн төвөөс Улаанбаатар хот хүртэлх зай, км	ҮСХ	2022
Нийгмийн Хувьсагч үзүүлэлтүүд	5	Мэргэжилгүй ажилгүй иргэд	Хувь (мэргэжилгүй гэдэгт боловсролгүй болон бага, суурь, бүрэн дунд боловсролтой ажилгүй иргэдийг хамруулав)	ҮСХ	2022
	6	Гэр бүл салалтын түвшин	1000 хүнд ногдох	ҮСХ	2022
	7	Гэмт хэргийн түвшин	1000 хүнд ногдох	ҮСХ	2022
	8	Нэг их эмчид ногдох хүний тоо		ҮСХ	2022
Байгаль орчны Хувьсагч үзүүлэлтүүд	9	Ой модыг огтолсон газар	Нийт ойн сан бүхий газарт эзлэх хувь	ГЗБГЗЗГ	2022
	10	Ойн түймэр	Давхардсан тоогоор	ҮСХ	2022
	11	Ширгэсэн гол горхи	Тоо	Усны газар	2022
	12	Мал сүргийн нягтрал	1 км ² -д ногдох малын тоо, хонин толгой	ҮСХ	2022
	13	Агаарын бохирдол NO ₂ түвшин	мкг/м ³ , аймгийн төвд	ҮСХ	2022
	14	Агаарын бохирдол SO ₂ түвшин	мкг/м ³ , аймгийн төвд	ҮСХ	2022

Ашигласан үзүүлэлтүүд

Аймаг	Үзүүлэлтүүд													
	Эдийн засгийн хувьсагч үзүүлэлтүүд				Нийгмийн хувьсагч үзүүлэлтүүд				Байгаль орчны хувьсагч үзүүлэлтүүд					
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Архангай	452918	0.7	1	477	0	0.9	5.6	462	0.02	3	20	228	38	15
Баян-Өлгий	282455	4.4	10.6	1709	40	0.8	2.7	380	0.00	11	9	83	19	7
Баянхонгор	577581	1.7	12.7	639	83	1.3	5.0	426	0.03	0	0	50	34	21
Булган	745193	1.5	6	336	38	1.2	7.6	542	0.06	9	0	153	41	11
Говь-Алтай	779030	0.9	14.8	1037	71	0.4	4.0	277	0.04	1	0	30	41	36
Говьсүмбэр	907306	1.9	5.5	223	38	2.5	7.9	266	0.00	1	0	130	12	16
Дархан-Уул	536516	2.3	8.2	223	20	3.7	6.3	321	0.00	2	0	204	23.5	12
Дорноговь	1210345	5.9	0.9	450	96	2.8	8.7	278	0.00	0	0	44	27	6
Дорнод	725951	3.2	8.1	661	55	2.7	6.7	413	0.30	52	0	63	21	11
Дундговь	709925	1.1	5	275	62	1.5	5.3	336	0.00	0	0	68	20	9
Завхан	617430	1.0	12.3	1023	36	0.8	5.6	409	0.04	8	1	80	18	13
Орхон	1691945	1.6	9.9	373	11	3.2	6.7	241	0.00	0	0	509	58.5	7
Өвөрхангай	443622	1.1	6.1	431	51	1.3	6.1	384	0.04	3	1	124	38	47
Өмнөговь	4986458	5.0	6.7	575	50	2.1	7.5	301	0.01	0	0	24	33	51
Сүхбаатар	776089	0.7	3	565	45	1.2	7.8	415	0.00	21	0	105	22	7
Сэлэнгэ	632645	2.3	7.8	321	58	2.1	7.2	428	0.16	23	0	100	23	5
Төв	696355	1.4	5.3	43	52	1.5	8.2	405	0.02	8	27	123	14	8
Увс	501794	1.6	9	1417	59	0.8	3.4	386	0.03	6	0	83	23	7
Ховд	574981	1.4	8.5	1487	60	1.2	5.9	298	0.01	5	12	70	28	16
Хөвсгөл	434436	1.8	10.7	779	64	1.9	6.2	467	0.18	6	12	112	19	12
Хэнтий	682995	1.3	3.4	338	87	1.4	8.9	377	0.01	15	0	117	15	5

Байгаль орчны эмзэг байдлын олон хувьсагчтай хэмжүүрийн үр дүн

Аймаг	Үзүүлэлтүүд													
	Эдийн засгийн хувьсагч үзүүлэлтүүд				Нийгмийн хувьсагч үзүүлэлтүүд				Байгаль орчны хувьсагч үзүүлэлтүүд					
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Архангай	0.04	0.00	0.01	0.26	0.00	0.14	0.47	0.73	0.07	0.06	0.74	0.42	0.56	0.22
Баян-Өлгий	0.00	0.71	0.70	1.00	0.42	0.12	0.00	0.46	0.01	0.21	0.33	0.12	0.15	0.04
Баянхонгор	0.06	0.20	0.85	0.36	0.87	0.25	0.36	0.61	0.10	0.00	0.00	0.05	0.47	0.35
Булган	0.10	0.17	0.37	0.18	0.40	0.23	0.79	1.00	0.19	0.17	0.00	0.27	0.62	0.13
Говь-Алтай	0.11	0.05	1.00	0.60	0.74	0.00	0.21	0.12	0.14	0.02	0.00	0.01	0.62	0.67
Говьсүмбэр	0.13	0.24	0.33	0.11	0.40	0.62	0.84	0.08	0.00	0.02	0.00	0.22	0.00	0.24
Дархан-Уул	0.05	0.31	0.53	0.11	0.21	1.00	0.57	0.27	0.01	0.04	0.00	0.37	0.25	0.15
Дорноговь	0.20	1.00	0.00	0.24	1.00	0.72	0.97	0.12	0.00	0.00	0.00	0.04	0.32	0.02
Дорнод	0.09	0.49	0.52	0.37	0.57	0.67	0.64	0.57	1.00	1.00	0.00	0.08	0.19	0.13
Дундговь	0.09	0.08	0.29	0.14	0.65	0.33	0.42	0.32	0.00	0.00	0.00	0.09	0.17	0.09
Завхан	0.07	0.07	0.82	0.59	0.38	0.10	0.47	0.56	0.13	0.15	0.04	0.12	0.13	0.17
Орхон	0.30	0.18	0.65	0.20	0.12	0.83	0.64	0.00	0.00	0.00	0.00	1.00	1.00	0.04
Өвөрхангай	0.03	0.09	0.37	0.23	0.53	0.26	0.54	0.48	0.14	0.06	0.04	0.21	0.56	0.91
Өмнөговь	1.00	0.82	0.42	0.32	0.52	0.50	0.78	0.20	0.02	0.00	0.00	0.00	0.45	1.00
Сүхбаатар	0.10	0.00	0.15	0.31	0.47	0.21	0.82	0.58	0.00	0.40	0.00	0.17	0.22	0.04
Сэлэнгэ	0.07	0.31	0.50	0.17	0.61	0.51	0.72	0.62	0.53	0.44	0.00	0.16	0.24	0.00
Төв	0.09	0.15	0.32	0.00	0.54	0.31	0.88	0.54	0.08	0.15	1.00	0.20	0.04	0.07
Увс	0.05	0.18	0.58	0.82	0.62	0.10	0.11	0.48	0.11	0.12	0.00	0.12	0.24	0.04
Ховд	0.06	0.15	0.55	0.87	0.63	0.24	0.51	0.19	0.02	0.10	0.44	0.09	0.34	0.24
Хөвсгөл	0.03	0.22	0.71	0.44	0.67	0.43	0.56	0.75	0.59	0.12	0.44	0.18	0.15	0.15
Хэнтий	0.09	0.12	0.18	0.18	0.91	0.28	1.00	0.45	0.04	0.29	0.00	0.19	0.06	0.00

ХАВСРАЛТ

Өрсөлдөх чадвар судлалын тухай ерөнхий ойлголт

Өрсөлдөх чадвар нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд эдийн засгийн ухаанд өргөнөөр хэрэглэгдэх болсон олон талт, цогц ойлголт юм. Аливаа үндэстний амжилтыг тайлбарлаж болох бүхий л хүчин зүйлсийг өрсөлдөх чадвар судалдаг.

Энэхүү ойлголтыг дөрвөн түвшинд илэрхийлж болох юм:

1. Үр ашиг

Өрсөлдөх чадвартай байна гэдэг нь бусдаас илүү байхыг хэлнэ хэмээх ерөнхий ойлголт бий. Ийм үр ашгийг тодорхойлох гол хүчин зүйл нь бүтээмж юм. Гэхдээ “Хэнд ч хэрэггүй юмыг үр ашигтай хийхээс хэрэггүй юм гэж үгүй” хэмээн Петер Дракерийн хэлсэн үг байдаг.

2. Сонголт

Тиймээс ч өрсөлдөх чадварыг аль салбарт харьцангуй давуу талыг бий болгож байгаагаа тодорхойлох стратегийн сонголт хэмээн тодорхойлж болно. Өрсөлдөх чадварын стратеги нь тухайн улс эсвэл аймаг юу хийж чадах вэ гэдгийг хараад зогсохгүй юу хийвэл зохих вэ гэдгийг харж байдаг. Боломжууд олшрох нь сонголт хийх замыг бүдгэрүүлэх талтай. Тухайн улс эсвэл аймаг (компани болон хувь хүн ч байж болно) бүх салбарт өрсөлдөх чадвараа сайжруулна гэж байхгүй. Өрсөлдөх чадвар гэдэг нь тухайн улс олон улсын хэмжээнд өрсөлдөхдөө бусдаас илүү нэмүү үнэлэмж бий болгох боломж ямар салбарт байгааг тодруулж, сонголт хийхийг хэлнэ.

3. Нөөц

Тэрхүү сонголтоо хэрэгжүүлэхийн тулд олон янзын нөөц бололцоогоо хэрхэн дайчлахаас өрсөлдөх чадвар нь шалтгаална. Засгийн газар, дэд бүтэц, технологи, санхүү, боловсрол зэргээс энэхүү нөөц бололцоонууд бий болдог. Олон улсын хэмжээнд улс орнууд эдгээр нөөцөд хүрэхийн тулд эсвэл тэднийг удирдахын тулд өрсөлдөж байна.

4. Зорилтууд

Өрсөлдөх чадвар нь өөрөө зорилт биш, харин түүнд хүрэх эдийн засгийн хэрэгсэл юм гэдэгт эрдэмтэд үндсэндээ санал нэгддэг. Гэхдээ энэхүү

хэрэгсэл нь улс үндэстнийг бүрдүүлж буй эдийн засгийн талуудыг өдөөх зорилтуудтай холбоотой бөгөөд тэдгээрээс хамаарч байдаг.

- a) Аж ахуйн нэгжүүдийн хувьд урт хугацаанд өгөөжтэй ажиллах чадвар буюу тогтвортой ашиг орлого чухал. Эдийн засгийн судалгаанууд энэхүү ойлголтыг маш сайн тодорхойлсон бөгөөд өрсөлдөх чадварын стратегийн салбарт ч үүнийг тайлбарласан байдаг.
- b) Улс үндэстнүүд хөгжил цэцэглэлт буюу бидний тайлбарладагчлан “эдийн засгийн өсөлт” ба “бусад зүйл” хэмээх ойлголтод хүрэхийг зорьдог. Ингэхдээ тухайн улсын эдийн засаг ба нийгмийн хөгжилтэй хамт “бусад зүйл” хэмээх зорилго нь хувьсан өөрчлөгддөг юм. Ядуу орны хувьд хоол хүнс болон орон байрыг ард түмэндээ хүртээмжтэй байлгахыг чухалчилж байхад илүү хөгжсөн орон байгаль орчны хамгаалал, боловсрол зэрэгт илүү ач холбогдол өгч байх жишээтэй. Гэхдээ аль ч орных нь хувьд эдийн засгийн өсөлт нь суурь шаардлага хэвээр үлдэх бөгөөд энэ нь “хэрэгтэй боловч хангалтгүй” байдаг нөхцөл юм.
- c) Хувь хүмүүс өөрсдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх сонирхолтой байдаг.

Эдгээр ойлголтыг нэгтгэх замаар өрсөлдөх чадварыг дэлгэрэнгүй томъёолбол:

Улс орнуудын өрсөлдөх чадвар судлал нь эдийн засгийн шинжлэх ухааны нэгэн салбар бөгөөд аливаа орны компаниуд нь илүү өндөр ашиг орлоготой, ард түмэн нь илүү чинээлэг, хангалуун амьдралтай байх орчныг бүрдүүлж, хөгжүүлэх талаар бодит байдал, бодлого хоёрыг харьцуулан судалдаг.

“Улс орнуудын өрсөлдөх чадвар судлал нь эдийн засгийн шинжлэх ухааны нэгэн салбар бөгөөд...”

Өрсөлдөх чадвар судлал нь 1980-аад оны эхэн үеэс судлагдаж эхэлсэн харьцангуй шинэ салбар юм. Хэдийгээр эдийн засгийн олон ойлголт дээр суурилсан ч, эх үндэс нь сонгодог эдийн засагчид (орчин цагийн эдийн засгийн онолыг үндэслэгч Адам Смит, Давид Рикардо, Жан Батист Сей гэх мэт) –аас улбаатай. Жишээ нь “харьцангуй давуу талын онол”-ыг дурдаж болох юм.

“...бодит байдал. бодлого хоёрыг харьцуулан судалдаг.”

Бие хүнээс төдийлөн хамаарахгүй хүчин зүйлс болон хүний оролцоогоор бий болж буй төрийн бодлогуудын нийлэмжийн үр дүнд улс орны өрсөлдөх чадварын орчин бүрддэг. Энэхүү хүчин зүйлс гэдэгт байгалийн нөөц, газар, байгалийн гамшиг (үер үс, ган гачиг), өвчин тахал, дайн дажин зэрэг эрсдэл орно. Эдгээр эрсдлийг бууруулахын тулд хүмүүсийн амьдралд янз бүрийн стандартууд нэвтрүүлж мөрдүүлэх, тэднийг вакцинжуулалтад хамруулах гэх мэтээр шийдэх боломжтой. Гэхдээ мэдээж байгалийн баялгийн хомс байдлын эсрэг авах арга хэмжээний боломж хязгаарлагдмал гэдэг нь тодорхой. Харин бодлогыг бол хүмүүс өөрсдөө тодорхойлох ба хүсвэл сайжруулж, өөрчилж болдог.

“орчныг бүрдүүлж, хөгжүүлэх...”

Бодит байдал, бодлого хоёр хамтдаа аливаа улс өрсөлдөх чадварын орчноо зөв бүрдүүлэх стратеги болон үйл ажиллагааны эрх чөлөөний хэм хэмжээг тодорхойлдог. Энэ нь урт хугацаанд үргэлжлэн сайжрах үйл явц учир “хөгжүүлэх” гэсэн үг хэрэглэсэн болно.

“...компаниуд нь илүү өндөр ашиг орлоготой...”

Аливаа улс зөвхөн тэсч үлдэх биш, ер нь өөрийн өрсөлдөх чадварын орчноо амжилттай бүрдүүлэх боломжтой. Зарим улс эдийн засаг нь хэдий бага ч гэсэн гол нь тогтвортой өсч байхад баяртай байдаг. Тэдний хувьд хамгийн чухал нь амьдралын чанар, түүхэн өв соёлоо хадгалж үлдэх бөгөөд энэ байдлаараа өрсөлдөх чадвараа дээшлүүлж байгаагаа харуулахад хангалттай гэж үздэг. Түүхийн шалгуураар үзэхэд энэ нь дэвшилтэй мэт боловч өрсөлдөх чадварын хувьд тэд аажмаар доройтсоор байжээ. Иймд “илүү” хэмээн тодотгосныг улс орнууд өөрсдийн өрсөлдөх чадвараа бүрэн дайчлан ажиллах чадавхи хэмээн ойлгож болох юм.

“...ард түмэн нь илүү чинээлэг хангалуун амьдралтай байх...”

Өрсөлдөх чадвараа дээшлүүлэх эцсийн зорилго нь иргэдийн орлого, амьжиргааны стандарт, амьдралын чанар зэргээр хэмжигдэх ард түмний чинээлэг хангалуун байдлыг өсгөхөд оршдог. Иймээс хэдий “чинээлэг хангалуун байдал” гэдэг нь өрсөлдөх чадварыг эдийн засгийн бус талаас нь илэрхийлдэг ч, ямар ч үнээр хамаагүй өрсөлдөх чадвараа сайжруулах гэж зүтгэх

нь урт хугацааны хувьд тийм ч тогтвортой, зохистой шийдэл биш болохыг харуулдаг юм. Өрсөлдөх чадвар нь зөвхөн бүтээмж эсвэл ашгийн тухай биш ажээ. Хар ухаанаар бодоод үзсэн ч бүтээж буй баялгаасаа хуваалцаагүй ард түмэндээ боловсрол, дэд бүтэц болон эрүүл мэндийн хангалттай баталгаа олгодоггүй, улс төрийн болоод нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж өгдөггүй улс орон урт хугацааны туршид хөгжиж чадахгүй гэдгийг хүн бүр мэднэ.

Орчин үеийн эдийн засгийн сэтгэлгээний хамгийн хүчирхэг ойлголтуудын нэг нь өрсөлдөх чадвар болж байна. Өрсөлдөх чадвар судлал нь боловсрол, шинжлэх ухаан, улс төрийн тогтвортой байдал, үнэлэмж зэрэг “эдийн засгийн бус” хүчин зүйлсийн нөлөөг нэмж тооцдог болсноор эдийн засгийн сонгодог онолд хувь нэмэр оруулсан. Нэгэнт өрсөлдөх чадвар олон ойлголтоос бүрддэг тул өрсөлдөх чадварын талаар олон янзын тодорхойлолт урган гарах болжээ. Улс орныг цэцэглэн хөгжүүлж, ард түмнийг өнө удаан, чинээлэг хангалуун амьдралд хүргэх бодлого боловсруулах хэрэгсэл гэдэг утгаараа өрсөлдөх чадварын тодорхойлолт нь өргөн хүрээтэй, олон талтай байх нь ойлгомжтой.

Олон хүн өрсөлдөх чадварыг хувь хүн, байгууллага эсвэл улс үндэстэн бусдаасаа илүү байх, хожих, хожигдохтой холбон ойлгодог. Угтаа бол өрсөлдөх чадвартай хүн, байгууллага эсвэл өрсөлдөх чадвартай улс үндэстэн нь бусдаас илүү гарч чадах салбартаа харьцангуй давуу тал үүсгэж, бэхжүүлж байдаг гэж хэлэх нь илүү зөв юм. Бүх салбарт жигд өрсөлдөх чадвартай байна гэдэг нь бараг боломжгүй. Тийм учраас сул талаа бусад давуу талаараа нөхдөг.

Сүүлийн үед үндэстэн дамнасан корпорацууд аутсорсинг болон оффшоринг стратегийг түлхүү хэрэглэх болсон нь ч үүнтэй холбоотой. Төрөлжилт буюу мэргэшших нь өрсөлдөх чадварт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Эцэст нь өрсөлдөх чадвар угтаа чадавхийг “дээшлүүлэхэд” чиглэгдэнэ. Амжилтад хүрсэн компаниуд ч ирээдүйд илүү ихэд хүрэхийг чармайж, илүү өндөр зорилт дэвшүүлдэг. Өрсөлдөх чадвараа сайжруулсан орнууд ч өөрсдийн нөөц боломж, чадавхыг бүрэн ашиглахыг хичээж байдаг. Үүнээс үзэхэд, хувь хүн, байгууллага, улс үндэстэн бүр дээд зэргээр хүчин чадлаа дайчилж, хамгийн өндөр амжилтад хүрэхэд л өрсөлдөх чадварын утга учир оршдог.

Мэдээллийн эх сурвалж, тайлбар

1. Эдийн засгийн тамир тэнхээ

Эдийн засаг

- 1.1.01 Дотоодын нийт бүтээгдэхүүн
Статистик мэдээлэл
Тэрбум төгрөг, оны үнээр
2022
ҮСХ
- 1.1.02 Дотоодын нийт бүтээгдэхүүн (%)
Ерөнхий мэдээлэл
Улсын ДНБ-д эзлэх хувь
2022
ҮСХ
- 1.1.03 Нэг хүнд ногдох ДНБ
Статистик мэдээлэл
Мянган төгрөг, оны үнээр
2022
ҮСХ
- 1.1.04 Эдийн засгийн хөгжлийн түвшин
Санал асуулга
Аймгийн эдийн засаг өнгөрсөн нэг жилтэй харьцуулахад хөгжиж байна / хөгжихгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 1.1.05 Хэрэглээний үнийн индекс
Статистик мэдээлэл
Жилийн, хувь
2022
ҮСХ
- 1.1.06 Эдийн засаг-Бизнес
Санал асуулга
Аймгийн эдийн засгийн нөхцөл байдал бизнесийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлж байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 1.1.07 Ногоон эдийн засгийн ойлголт
Санал асуулга
Аймгийн бизнесийн байгууллагуудын ногоон эдийн засгийн талаарх ойлголт.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Эдийн засгийн салбарууд

- 1.2.01 Эдийн засгийн салбарууд
Ерөнхий мэдээлэл
Хөдөө аж ахуй, аж үйлдвэр ба барилга, үйлчилгээний салбаруудын ДНБ-д эзлэх хувь
2022
ҮСХ

- 1.2.02 Эдийн засгийн төрөлжилт
Санал асуулга
Эдийн засгийн төрөлжилт сайн буюу аймгийн эдийн засаг нэг салбараас хараат бус, олон салбараас бүрдэж чадаж байна / чадахгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 1.2.03 Аж үйлдвэр, барилгын салбарын хөгжил
Статистик мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
2022
ҮСХ
- 1.2.04 Аж үйлдвэрийн салбарын борлуулалт
Ерөнхий мэдээлэл
Тэрбум төгрөг
2022
ҮСХ
- 1.2.05 Аж үйлдвэрийн салбарын борлуулалт(%)
Статистик мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 1.2.06 Барилгын ажил
Статистик мэдээлэл
Сая төгрөг
Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт их засварын ажил
2022
ҮСХ
- 1.2.07 Худалдааны салбарын борлуулалт
Статистик мэдээлэл
Сая төгрөг
Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт, жилд 50 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн
2022
ҮСХ
- 1.2.08 Малын тоо
Статистик мэдээлэл
Бодод шилжүүлснээр, мянган бод
2022
ҮСХ
- 1.2.09 Тариалсан талбай
Статистик мэдээлэл
Га
2022
ҮСХ
- 1.2.10 Хураасан ургац - үр тариа
Ерөнхий мэдээлэл
Тонн
2022
ҮСХ

- 1.2.11 Хураасан ургац – төмс, хүнсний ногоо
Ерөнхий мэдээлэл
Тонн
Тооцоолол
2022
ҮСХ
- 1.2.12 100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох малын тоо
Статистик мэдээлэл
Хонин толгойд шилжүүлсэн
2022
ҮСХ

Хүн амын амьжиргааны түвшин

- 1.3.01 Амьжиргааны түвшин
Санал асуулга
Аймгийн иргэдийн амьжиргааны түвшин өнгөрсөн нэг жилтэй харьцуулахад сайжирсан / сайжраагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 1.3.02 Хадгаламж
Статистик мэдээлэл
Нэг хүнд ногдох, мянган төгрөг
Тооцоолол: Нийт хадгаламжийн үлдэгдлийг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 1.3.03 Зээл
Статистик мэдээлэл
Нэг хүнд ногдох, мянган төгрөг
Тооцоолол: Нийт зээлийн өрийн үлдэгдлийг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 1.3.04 Нэг малчин өрхөд ногдох малын тоо
Ерөнхий мэдээлэл
Тооцоолол
2022
ҮСХ

Хөдөлмөр эрхлэлт

- 1.4.01 Хөдөлмөрийн насны хүн амын тоо
Ерөнхий мэдээлэл
15-59 насны хүн амын тоо
2022
ҮСХ

- 1.4.02 Эдийн засгийн идэвхтэй хүн ам
 Статистик мэдээлэл
 Нийт хүн амд эзлэх хувь
 Тооцоолол: Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч) буюу тухайн цаг хугацаанд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийн тоог нийт хүн амын тоонд харьцуулж тооцов.
 2022
 ҮСХ
- 1.4.03 Хөдөлмөр эрхлэлт
 Ерөнхий мэдээлэл
 Ажиллагсдын тоо, мянган хүн
 Ажиллагсад гэдэгт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхэлж буй (сүүлийн 7 хоногт 1-ээс дээш цагаар оролцсон) иргэнийг хамруулна.
 2022
 ҮСХ
- 1.4.04 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
 Статистик мэдээлэл
 Хувь
 Тооцоолол: Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцов.
 2022
 ҮСХ
- 1.4.05 Ажиллах хүчний оролцооны түвшин
 Статистик мэдээлэл
 Хувь
 Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүн
 2022
 ҮСХ
- 1.4.06 Төрийн албан хаагчид
 Ерөнхий мэдээлэл
 Нийт ажиллагсдын тоонд эзлэх хувь
 Тооцоолол: Төрийн албан хаагчдын тоог нийт ажиллагсдын тоонд харьцуулж тооцов.
 2022
 ҮСХ
- 1.4.07 Малчид
 Ерөнхий мэдээлэл
 Нийт ажиллагсдын тоонд эзлэх хувь
 Тооцоолол: Нийт малчдын тоог нийт ажиллагсдын тоонд харьцуулж тооцов.
 2022
 ҮСХ
- 1.4.08 Ажилгүй иргэдийн тоо
 Ерөнхий мэдээлэл
 Ажиллах хүчний судалгааны дүнгээр.
 Ажилгүй иргэн гэдэгт тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хамруулна.
 2022
 ҮСХ

- 1.4.09 Ажилгүйдлийн түвшин
Статистик мэдээлэл
Хувь
Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан дүн
2022
ҮСХ
- 1.4.10 Ажилгүйчүүдийн тоо
Статистик мэдээлэл
Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ
- 1.4.11 Хүн амын ачаалал
Статистик мэдээлэл
Хувь
Тооцоолол: 15 хүртэлх болон 65 ба түүнээс дээш насны нийт хүн амын тоог 15-64 насны хүн амын тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 1.4.12 Дундаж цалин
Статистик мэдээлэл
Сарын, мянган төгрөг
Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин
2022
ҮСХ
- 1.4.13 Ажлын байрны хүрэлцээ
Санал асуулга
Аймагт ажлын байрны хүрэлцээ хангалттай байна / хангалтгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 1.4.14 Хөдөлмөрийн бирж
Санал асуулга
Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэдийг ажил хайж, олоход нь тусалж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

2. Засаглалын үр ашиг

Аймгийн төсөв

- 2.1.01 Төсвийн орлого
Ерөнхий мэдээлэл
Сая төгрөг
Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор
2022
ҮСХ
- 2.1.02 Төсвийн зарлага
Ерөнхий мэдээлэл
Сая төгрөг
2022
ҮСХ

- 2.1.03 Төсвийн орлого, зарлагын харьцаа
Статистик мэдээлэл
Хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 2.1.04 Төсвийн орлого (%)
Статистик мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 2.1.05 Төсвийн зарлага (%)
Статистик мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 2.1.06 Төсвийн тэнцэл
Ерөнхий мэдээлэл
Төсвийн ашиг (алдагдал), сая төгрөг
Тооцоолол
2022
ҮСХ
- 2.1.07 Төсвийн тэнцэл (%)
Ерөнхий мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 2.1.08 Аймгийн төсвийн удирдлага
Санал асуулга
Аймгийн төсвийн удирдлага буюу төсвийн зарцуулалт оновчтой байна / оновчгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.1.09 Төсвийн эрх мэдэл
Санал асуулга
Аймгийн төсвийн зарцуулалтад иргэд тодорхой хэмжээгээр хяналт тавьж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.1.10 Татвараас зайлсхийх
Санал асуулга
Татвараас зайлсхийх үзэгдэл аймгийн бизнес эрхлэгчдийн дунд бага байдаг / их байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.1.11 Төсвийн ил тод байдал
Санал асуулга
Аймгийн төсвийн зарцуулалт, худалдан авалтын мэдээлэл ил тод байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 2.1.12 Орон нутгийн төсвийн орлогод ААНОАТ-аас төвлөрсөн дүн
Статистик мэдээлэл
Орон нутгийн төсвийн орлогод ААНОАТ-аас төвлөрсөн дүн
2022
ҮСХ мэдээ авсан

Институцийн тогтолцоо

- 2.2.01 Аймгийн удирдлагын бодлого, шийдвэр
Санал асуулга
Аймгийн удирдлагын бодлого, шийдвэр оновчтой бөгөөд аймгийн хөгжилд хувь нэмэр оруулж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.2.02 Ил тод байдал
Санал асуулга
Аймгийн удирдлагын бодлого, шийдвэрүүд ил тод байдаг / байдаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.2.03 Хүнд суртал
Санал асуулга
Бизнесийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын хүнд суртал саад болдоггүй / саад болдог.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.2.04 Авлига, хээл хахууль
Санал асуулга
Аймгийн төрийн албан хаагчдын авлигад өртөх байдал харьцангуй бага / их байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.2.05 Төрийн үйлчилгээ
Санал асуулга
Төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүртээмжтэй байж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Бизнесийн эрхзүй

- 2.3.01 Тендер
Санал асуулга
Аймгаас зарлаж буй тендерүүд ил тод, шударга байж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.3.02 Шударга бус өрсөлдөөн
Санал асуулга
Аймгийн бизнесийн орчинд шударга бус өрсөлдөөн бага байдаг / их байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 2.3.03 Албан бус эдийн засаг
Санал асуулга
Албан бус эдийн засаг (бүртгэлгүй бизнесийн үйл ажиллагаа) нь эдийн засгийн хөгжилд саад болдоггүй / саад болдог.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.3.04 Захиргааны зохицуулалтууд
Санал асуулга
Бизнесийн таатай орчин бүрдэхэд аймгийн захиргааны зохицуулалтууд дэмжлэг болдог / дэмжлэг болдоггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.3.05 Гадаадын төсөл хөтөлбөр
Санал асуулга
Аймгийн бизнес эрхлэгчид гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрт хамрагдахад аймгийн удирдлагууд дэмжлэг болдог.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Нийгмийн тогтолцоо

- 2.4.01 Хууль ёс
Санал асуулга
Хууль ёс хүн бүрд тэгш үйлчилдэг / үйлчилдэггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.4.02 Орлогын тэгш бус байдал
Санал асуулга
Аймгийн иргэдийн орлогын тэгш бус байдал буюу баян хоосны ялгаа харьцангуй бага / харьцангуй их байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.4.03 Хүн амын төвлөрөл
Ерөнхий мэдээлэл
Нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь
Аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа нийт хүн амд хотын буюу аймгийн төв, суурин газарт амьдарч буй хүн амын эзлэх хувь
2022
ҮСХ
- 2.4.04 Шилжих хөдөлгөөн – хот
Статистик мэдээлэл
Аймгийн хүн ам Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн.
2022
ҮСХ мэдээ авсан
- 2.4.05 Шилжих хөдөлгөөн – аймгийн төв
Санал асуулга
Аймгийн хүн ам аймгийн төв рүү шилжих хөдөлгөөн бага байна / их байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 2.4.06 Шилжих хөдөлгөөн ба хүйсийн тэнцвэрт байдал
Санал асуулга
Шилжих хөдөлгөөн нь хүн амын хүйсийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөхгүй байна / сөргөөр нөлөөлж байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 2.4.07 Хүйсийн харьцаа
Ерөнхий мэдээлэл
100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоо
Тооцоолол: Эрэгтэй хүн амын тоог эмэгтэй хүн амын тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 2.4.08 Хүн амын насны бүтцийн хандлага
Статистик мэдээлэл
Нийт хүн амд 15-34 насны залуусын эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 2.4.09 Хүний хөгжлийн индекс
Статистик мэдээлэл
Дундаж наслалт, боловсрол, орлогын үзүүлэлтүүдээр хүний чадавхын хөгжлийг харуулсан индекс. Нөөц ашиглалтын хүснэгтийн 2011-2013 оны үр дүнгээр тодотгосон.
2022
ҮСХ
- 2.4.10 Жендерийн хөгжлийн индекс
Ерөнхий мэдээлэл
Эмэгтэйчүүдийн Хүний хөгжлийн индексийг (ХХИ) эрэгтэйчүүдийн ХХИ-д харьцуулсан харьцаа. Нөөц ашиглалтын хүснэгтийн 2011-2013 оны үр дүнгээр тодотгосон.
2022
ҮСХ
- 2.4.11 Жендерийн тэгш бус байдлын индекс
Статистик мэдээлэл
Хүйсийн тэгш бус байдлаас хамаарах эрүүл мэнд, шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөр эрхлэлт дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс
2022
ҮСХ
- 2.4.12 Гэмт хэрэг
Статистик мэдээлэл
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо
2022
ҮСХ

3. Бизнесийн үр ашиг

Бизнесийн орчин

- 3.1.01 Аж ахуйн нэгж, байгууллага
Ерөнхий мэдээлэл
Үйл ажиллагаа явуулж буй
Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо
2022
ҮСХ

- 3.1.02 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж
Статистик мэдээлэл
Үйл ажиллагаа явуулж байгаа хувийн болон хувийн хамтарсан аж ахуйн нэгж байгууллагын тоо
2022
ҮСХ
- 3.1.03 Хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж
Статистик мэдээлэл
50-иас дээш ажиллагсадтай
2022
ҮСХ
- 3.1.04 Хувиараа бизнес эрхлэх боломж
Санал асуулга
Аймагт хувиараа бизнес эрхлэх боломж их байдаг / бага байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.1.05 Бизнесийн таатай орчин
Санал асуулга
Аймагт бизнес эрхлэх таатай орчин бүрдэж чадсан / бүрдэж чадаагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.1.06 Бизнес эрхлэгчдийг дэмжигч байгууллагууд
Санал асуулга
Аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой аливаа үйл ажиллагаа явуулж буй байгууллага, холбоод бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг үр өгөөжтэй дэмжиж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.1.07 Төр, хувийн хэвшлийн түншлэл
Санал асуулга
Аймагт төр, хувийн хэвшлийн түншлэл хэрэгждэг / хэрэгждэггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.1.08 Аймгийн төрх байдал
Санал асуулга
Аймгийн онцлог бүсдэд үнэлэгдэх үнэлэмж нь бизнесийн хөгжилд эергээр нөлөөлдөг / сөргөөр нөлөөлдөг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.1.09 Гадаад зах зээл
Санал асуулга
Гадаад зах зээл рүү бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргах боломж сайн байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж

- 3.2.01 Чадварлаг удирдах ажилтан
Санал асуулга
Чадварлаг удирдах ажилтны олдоц сайн байдаг / муу байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 3.2.02 Санхүүгийн үр чадвар
Санал асуулга
Санхүүгийн чадварлаг мэргэжилтнүүдийн олдоц сайн байдаг / муу байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.2.03 Мэргэшсэн ажиллах хүч
Санал асуулга
Мэргэшсэн ажиллах хүчийг олж ажиллуулахад хялбар байдаг / хэцүү байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.2.04 Хөдөлмөрийн бүтээмж
Статистик мэдээлэл
Нэг ажилтанд ногдох ДНБ, мянган төгрөг
Тооцоолол
2022
ҮСХ
- 3.2.05 Сургалт
Санал асуулга
Компаниуд ажилтнаа мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахыг чухалчилдаг / чухалчилдаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.2.06 Мэргэшсэн ажиллах хүчний шилжих хөдөлгөөн
Санал асуулга
Чадварлаг, мэргэшсэн ажиллах хүч өөр аймаг, хотод шилжин ажиллах нь аймгийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрээгүй / хүрсэн.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Санхүү

- 3.3.01 Банк, санхүүгийн үйлчилгээ
Санал асуулга
Банк, санхүүгийн үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааг үр өгөөжтэй дэмжиж чаддаг / дэмжиж чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.3.02 Банкны салбарууд
Ерөнхий мэдээлэл
Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банкуудын нийт салбар, нэгжийн тоо
2022
МБ
- 3.3.03 Зээлийн өрийн үлдэгдэл
Статистик мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
Тооцоолол
2022
МБ.ҮСХ

- 3.3.04 Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл
Статистик мэдээлэл
Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь
Тооцоолол
2022
МБ
- 3.3.05 Зээл авах боломж
Санал асуулга
Бизнес эрхлэгчид зээл авахад хялбар байдаг / хэцүү байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.3.06 Хадгаламжийн үлдэгдэл
Статистик мэдээлэл
ДНБ-д эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 3.3.07 Банкуудын зээлийн хүү
Статистик мэдээлэл
Хувь
2022
МБ
- 3.3.08 Байгууллагын хөрөнгө оруулалт
Санал асуулга
Манай компани энэ жил бизнесийн хөрөнгө оруулалтаа хангалттай хэмжээгээр нэмэгдүүлж чадсан / чадаагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Менежментийн хэвшил

- 3.4.01 Компаниудын зохицох чадвар
Санал асуулга
Зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох компаниудын чадвар сайн байна / муу байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.4.02 Нягтлан бодох бүртгэл ба аудит
Санал асуулга
Бизнес эрхлэгчид нягтлан бодох бүртгэл, аудитын зарчмыг зохих хэмжээнд мөрддөг / мөрддөггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.4.03 Бизнесийн овсгоо самбаа
Санал асуулга
Аж ахуйн нэгжийн удирдах ажилтнууд бизнесийн овсгоо сайтай байдаг / муутай байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 3.4.04 Нийгмийн хариуцлага
Санал асуулга
Бизнес эрхлэгчид нийгмийн хариуцлагаа ухамсарладаг / ухамсарладаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

3.4.05 Компаниудын цахимжилт

Санал асуулга

Бизнес эрхлэгчид үйлчилгээний үйл ажиллагаа /сурталчилгаа, захиалга, төлбөр төлөлт зэрэг/ цахимжуулан хялбаршуулж чадсан / чадаагүй

2023

Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

4. Дэд бүтэц

Үндсэн дэд бүтэц

4.1.01 Газар нутаг

Ерөнхий мэдээлэл

Мянган км²

2022

ҮСХ

4.1.02 Хүн амын нягтшил

Ерөнхий мэдээлэл

1 км²-т ногдох хүний тоо

2022

ҮСХ

4.1.03 Алслагдсан байдал

Статистик мэдээлэл

Аймгийн төвөөс Улаанбаатар хот хүртэлх зай, км

2022

ҮСХ

4.1.04 Газарзүйн байршил

Санал асуулга

Аймгийн газарзүйн байршил нь бизнес эрхлэгчдэд давуу тал болдог / сүл тал болдог.

2023

Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

4.1.05 Зах зээлийн багтаамж

Статистик мэдээлэл

Нийт хүн амын тоо, мянган хүн

2022

ҮСХ

4.1.06 Хүн амын цэвэр өсөлт

Статистик мэдээлэл

1000 хүнд ногдох

2022

ҮСХ

4.1.07 Бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ

Санал асуулга

Аймгийн дэд бүтэц, барилгын бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний ажлын төлөвлөлт, санхүүжилт сайн байна / муу байна.

2023

Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

4.1.08 Тохижилт

Санал асуулга

Аймгийн төвд гэрэлтүүлэг, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, явган хүний зам, сандал, хогийн сав зэрэг тохижилтын ажил сайн хийгдсэн / муу хийгдсэн.

2023

Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 4.1.09 Эрчим хүч
Санал асуулга
Аймгийн хэмжээнд эрчим хүчний асуудлаа хангалттай шийдвэрлэж чадсан / чадаагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.10 Цахилгааны үнэ
Статистик мэдээлэл
Жилийн дундаж, кВтц/төг
2022
ҮСХ
- 4.1.11 Цахилгааны үүсгүүртэй малчин өрх
Статистик мэдээлэл
Нийт малчин өрхөд эзлэх хувь
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.1.12 Дулаан
Санал асуулга
Аймгийн хэмжээнд дулааны асуудлаа хангалттай шийдвэрлэж чадсан / чадаагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.13 Халаалтын үнэ
Статистик мэдээлэл
Жилийн дундаж, м2/төг
2022
ҮСХ
- 4.1.14 Цэвэр усны хүртээмж
Санал асуулга
Аймгийн хүн амын ундны усны хүртээмж чанар сайн / муу.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.15 Хог
Санал асуулга
Аймгийн хэмжээнд хогны асуудлаа хангалттай шийдвэрлэж чадсан / чадаагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.16 Замын чанар
Санал асуулга
Аймгийн авто замын чанар сайн байна / муу байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.17 Тээврийн хөгжил
Санал асуулга
Улаанбаатар хот руу ирж, очиход хүндрэл учирдаггүй / учирдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.18 Тээврийн хэрэгсэл
Статистик мэдээлэл
Хөдөлмөрийн насны 100 хүн амд ногдох авто машины тоо
Тооцоолол: Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоогоор тооцов.
2022
ҮСХ

- 4.1.19 Шатахууны үнэ
Статистик мэдээлэл
Нэг литр АИ-80 бензиний үнэ, жилийн дундаж төгрөг
2022
ҮСХ
- 4.1.20 Түгээлтийн сүлжээ
Санал асуулга
Аймгийн иргэд, бизнес эрхлэгчид бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотод борлуулахад хүндрэл учирдаггүй / учирдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.21 Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн
Санал асуулга
Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт хангалттай байдаг / хангалтгүй байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.22 Томоохон үйлчилгээний төвүүд
Санал асуулга
Томоохон үйлчилгээний төвүүдийн хүртээмж (худалдааны төв, зочид буудал, ресторан гэх мэт) хангалттай байна / хангалтгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.23 Худалдааны цэгийн хүртээмж
Статистик мэдээлэл
Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо
2022
ҮСХ
- 4.1.24 Халуун усны газар
Санал асуулга
Аймагт халуун усны газар хүртээмжтэй байдаг / хүртээмжгүй байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.1.25 Ногоон байгууламж
Санал асуулга
Аймгийн төвд ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн зэрэг тохижилтын ажил сайн хийгдсэн.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Технологийн дэд бүтэц

- 4.2.01 Холбооны салбарын нийт орлого
Статистик мэдээлэл
Сая төгрөг
2022
ҮСХ
- 4.2.02 Суурин утасны цэг
Статистик мэдээлэл
1000 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ

- 4.2.03 Мэдээллийн хүртээмж
Санал асуулга
Аймгийн иргэд мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.2.04 Мэдээллийн байгууллага
Санал асуулга
Аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд үнэн зөв, шуурхай, хүртээмжтэй ажиллаж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.2.05 Харилцаа, холбооны технологи
Санал асуулга
Харилцаа, холбооны технологи (интернэт, суурин болон үүрэн утас, шуудангийн үйлчилгээ) нь бизнесийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна / хангахгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.2.06 Чадварлаг инженерүүд
Санал асуулга
Өндөр ур чадвартай инженерүүдийн хүрэлцээ бизнесийн хэрэгцээг хангаж байна / хангахгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.2.07 Дижитал төхөөрөмжүүдийн хэрэглээ
Санал асуулга
Компаниудын дижитал хэрэгсэл болон технологийг (компьютер, интернэт гэх мэт) ашиглаж буй байдал сайн байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

Боловсрол, соёл

- 4.3.01 Сургуулийн өмнөх боловсрол
Санал асуулга
Сургуулийн өмнөх боловсролын байгууллага (ясли, цэцэрлэг)-ийн хүртээмж сайн байна / муу байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.3.02 Ерөнхий боловсролын сургууль
Ерөнхий мэдээлэл
Тоо
2022
ҮСХ
- 4.3.03 Бага дунд боловсрол
Санал асуулга
Бага, дунд боловсролын чанар сайн байна / муу байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.3.04 Дээд боловсрол
Санал асуулга
Дээд боловсрол эзэмшигчид нь өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж байна / хангахгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 4.3.05 Цэцэрлэгийн хамран сургалт
Статистик мэдээлэл
Хувь
Тооцоолол: Нийт цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоог 2-5 насны хүүхдийн тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 4.3.06 Бага боловсролын хамран сургалт
Статистик мэдээлэл
Хамран сургалтын хувь, бохир
2022
ҮСХ
- 4.3.07 Суурь боловсролын хамран сургалт
Статистик мэдээлэл
Хамран сургалтын хувь, бохир
2022
ҮСХ
- 4.3.08 Дунд боловсролын хамран сургалт
Статистик мэдээлэл
Хамран сургалтын хувь, бохир
2022
ҮСХ
- 4.3.09 Сурагч-багшийн харьцаа (цэцэрлэг)
Статистик мэдээлэл
Нэг багшид ногдох сурагчийн тоо
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.10 Сурагч-багшийн харьцаа (бага боловсрол)
Статистик мэдээлэл
Нэг багшид ногдох сурагчийн тоо
Хичээлийн жилийн эхэнд
2022
ҮСХ
- 4.3.11 Сурагч-багшийн харьцаа (ерөнхий боловсрол)
Статистик мэдээлэл
Нэг багшид ногдох сурагчийн тоо
Хичээлийн жилийн эхэнд
2022
ҮСХ
- 4.3.12 Гадаад хэл
Санал асуулга
Ажилтнуудын гадаад хэлний мэдлэг нь аж ахуйн нэгжийн хэрэгцээг хангаж байна / хангахгүй байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.3.13 Шинийг санаачлах чадвар
Санал асуулга
Аж ахуйн нэгжүүдийн шинийг санаачлах чадвар (шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх) сайн байна / муу байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга

- 4.3.14 Чөлөөт цагаа өнгөрөөх газар
Санал асуулга
Аймгийн иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх газар хангалттай байдаг / хангалтгүй байдаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.3.15 Мэргэжлийн урлагийн тоглолт
Ерөнхий мэдээлэл
Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо
2022
ҮСХ
- 4.3.16 Урлагийн байгууллагын үзэгчид
Статистик мэдээлэл
Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо, 100 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.17 Соёлын төв
Ерөнхий мэдээлэл
Соёлын төвийн тоо
2022
ҮСХ
- 4.3.18 Соёлын төвийн хүртээмж
Статистик мэдээлэл
Соёлын төвийн суудлын тоо, 100 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.19 Мүзейн үзэгчид
Статистик мэдээлэл
100 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.20 Номын сан
Ерөнхий мэдээлэл
Нийтийн номын сангийн тоо
2022
ҮСХ
- 4.3.21 Номын сангийн хүртээмж
Статистик мэдээлэл
Номын сангийн суудлын тоо, 1000 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.22 Номын сангийн уншигчид
Статистик мэдээлэл
Нийтийн номын сангийн байнгын уншигчдын тоо, 1000 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ

- 4.3.23 Уламжлалт соёл
Санал асуулга
Уламжлалт соёл өөрчлөгдөх, алдагдах байдал ажиглагдахгүй байна / ажиглагдаж байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.3.24 Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (Байгалийн ухаан)
Статистик мэдээлэл
ЭЕШ-ын байгалийн ухааны хичээлүүдийн дундаж оноо
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.25 Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (Нийгмийн ухаан)
Статистик мэдээлэл
ЭЕШ-ын нийгмийн ухааны хичээлүүдийн дундаж оноо
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.3.26 Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (Хүмүүнлэгийн ухаан)
Статистик мэдээлэл
ЭЕШ-ын хүмүүнлэгийн ухааны хичээлүүдийн дундаж оноо
Тооцоолол
2022
ҮСХ

Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин

- 4.4.01 Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц
Санал асуулга
Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалт хүн амын эрэлт хэрэгцээг хангаж чаддаг / хангаж чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.4.02 Дундаж наслалт
Статистик мэдээлэл
Хүн амын дундаж наслалт
2022
ҮСХ
- 4.4.03 Төрөлтийн ерөнхий коэффициент
Статистик мэдээлэл
1.000 хүнд ногдох амьд төрсөн хүүхдийн тоо
Тооцоолол: Жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 4.4.04 Төрөлтийн хүйсийн харьцаа
Ерөнхий мэдээлэл
100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо
2022
ҮСХ

- 4.4.05 Эхийн эндэгдлийн түвшин
Ерөнхий мэдээлэл
100.000 амьд төрөлтөд ногдох эндсэн эхийн тоо
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.4.06 Нялхсын эндэгдлийн түвшин
Статистик мэдээлэл
1.000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тоо
2022
ҮСХ
- 4.4.07 Нас баралтын ерөнхий коэффициент
Статистик мэдээлэл
1.000 хүнд ногдох нас барсан хүний тоо
Тооцоолол: Жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж тооцов.
2022
ҮСХ
- 4.4.08 Нас баралтын хүйсийн харьцаа
Ерөнхий мэдээлэл
100 эмэгтэйд ногдох эрэгтэй нас барсан хүний тоо
2022
ҮСХ
- 4.4.09 Эрүүл мэндийн тусламж (их эмч)
Статистик мэдээлэл
Нэг их эмчид ногдох хүний тоо
2022
ҮСХ
- 4.4.10 Эрүүл мэндийн тусламж (сувилагч)
Статистик мэдээлэл
Нэг сувилагчид ногдох хүний тоо
2022
ҮСХ
- 4.4.11 Халдварт өвчний тархалт
Статистик мэдээлэл
10.000 хүнд ногдох
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.4.12 Хорт хавдрын өвчлөлт
Статистик мэдээлэл
10.000 хүнд ногдох
2022
ҮСХ
- 4.4.13 Жирэмсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн хяналтад хамрагдалт
Статистик мэдээлэл
Хувь. Жирэмсний эхний 3 сартайд
2022
ҮСХ

- 4.4.14 Хүнсний аюулгүй байдал
Санал асуулга
Аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлын асуудлыг хангалттай шийдвэрлэж чадсан / чадаагүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.4.15 Биеийн тамир, спортоор хичээллэгчид
Статистик мэдээлэл
1000 хүнд ногдох(давхардсан тоогоор)
Тооцоолол
2022
ҮСХ
- 4.4.16 Спорт заал
Ерөнхий мэдээлэл
Тоо
2022
ҮСХ
- 4.4.17 Цол зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчдын тоо
Ерөнхий мэдээлэл
Тоо
2022
ҮСХ
- 4.4.18 Цаг уур
Санал асуулга
Аймгийн бизнес эрхлэгчид цаг уурын аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, даван туулж чаддаг / чаддаггүй.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.4.19 Цэвэр агаар
Санал асуулга
Аймгийн төвд агаарын бохирдол харьцангуй бага байна / их байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.4.20 Уул уурхай
Санал асуулга
Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчныг сүйтгэх байдал ажиглагддаггүй / ажиглагддаг.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга
- 4.4.21 Амьдралын чанар
Санал асуулга
Иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах нөхцөл сайн байна / муу байна.
2023
Бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга